# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХҮНИЙ НӨӨЦ, ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Н.ВАНСЭМБЭРҮҮГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, хүний нөөцийн манлайллаар хангана.”** | | | | | | | |
| 1. | Хүний нөөцийн чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын албан хаагчдад арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | Хэрэгжилтийн хувь | 90% | 92% | Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон түүнийг даган батлагдсан дүрэм журмыг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэн албан хаагчдад танилцуулан ажиллаж байна.<br>Албан хаагчид хууль тогтоомжоор хүлээсэн эрх, үүргээ биелүүлэх, нийгмийн баталгаагаа хангуулах, ажиллах боломжоор хангагдахад зөвлөгөө, мэдээллийг хүргэн ажиллалаа.<br>Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоо шинэчлэн батлагдсан Монгол Улсын Засгийн газрын тогтоолыг танилцуулан ажиллалаа. | 2025.01. 02-06.15 | 100 |
| 2. | Аймгийн хүний нөөцийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулан, хэрэгжилтийг хангуулна. | Хэрэгжилтийн хувь | 0% | 50% | Аймгийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан ажиллаж байна.<br>Тус хөтөлбөрийн төслийг боловсруулж, бүх шатны төрийн байгууллагуудад хүргүүлж, нэмэлтээр тусгах санал, шаардлагатай судалгааг гарган авсан.<br>Хөтөлбөрийг эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулахаар ажиллаж байна. | 2025.01. 02-06.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангана. | Төлөвлөгөө-ний гүйцэтгэлийн хувь | 90% | 92% | Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг 3 зорилт 12 арга хэмжээний хүрээнд, нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг 4 зорилт 20 арга хэмжээний хүрээнд боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хугацааны дагуу зохион байгуулан ажиллаж байна. | 2025.01. 02-06.15 | 100 |
| 4 | Хүний нөөцийн чиглэлээр гарч буй шийдвэрийн төслийг боловсруулж, албажуулна. | Хэрэгжилтийн хувь | 95% | 97% | Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог 2023 оны 11 дүгээр сард батлагдсны дагуу мөрдлөг болгон ажиллаж байна.<br>2025 онд шинээр томилогдсон 4 албан хаагч, хүүхэд асрах чөлөөнөөс ирсэн 1 албан хаагчийг томилох шийдвэрийг боловсруулан албажуулж ажиллалаа. Мөн 5 албан хаагчийг чөлөөлөх шийдвэрийг боловсруулан, баталгаажуулж ажилласан байна. | 2025.01. 02-06.15 | 100 |
| 5 | Хүний нөөцийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллана. | Ил тод байдлын хувь, хугацаанд нь тайлагнасан хувь | 65%<br>75% | 70%<br>85% | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хүний нөөцийн ил тод байдлыг хангаж ажиллаж байна.<br>Байгууллагын цахим хуудасны ил тод байдал хэсэг хүний нөөцийн ил тод байдал цэсийг үүсгэж, хуульд заасан мэдээллийг байршуулсан болно. | 2025.01. 02-06.15 | 100 |
| 6 | Байгууллагын бүтэц, орон тооны өөрчлөлтийн төслийг бэлтгэж, шийдвэр гаргуулах, батлагдсан бүтцийн дагуу төрийн албан хаагчдын хөдөлгөөнийг ХНУМС болон ТБУМС-д хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | 95%<br>2 удаа | 96%<br>2 удаа | Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоо батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 37 дугаар тогтоол шинэчлэн батлагдсан холбогдуулан шинэ хэлтэс нэмэгдэх, албан тушаал өөрчлөх зэргээр байгууллагын бүтэц, орон тооны шийдвэрийн төслийг боловсруулан эрх | 2025.01. 02-06.15 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүхий албан тушаалтанд танилцуулан ажиллаж байна.<br>Батлагдсан бүтцийн хүрээнд төрийн албан хаагчийн хөдөлгөөнийг системд бүртгэнэ. | | |
| 7 | Шинэчлэн батлагдсан бүтцийн дагуу албан тушаалын тодорхойлолтуудыг боловсруулж, батлуулна. | Батлагдсан албан тушаалын тодорхойлолтын тоо | 46 | 24 | Байгууллагын бүтэц, чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбогдуулан ажлын байрны шинжилгээ хийх, албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг байгуулагдан хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж байна. | 2025.01.<br>02-06.15 | 90 |
| 8 | Төрийн албан хаагчийн мэдээллийг Хүний нөөцийн удирдлага мэдээллийн системд үнэн зөв бүртгэж, хөдөлгөөн, цалингийн өөрчлөлтийг цаг тухай бүрт нь гүйцэтгэнэ. | Хэрэгжилтийн хувь,<br>Хугацаанд нь хэрэгжүүлсэн байдал | 97% | 98% | Батлагдсан бүтэц, орон тооны мэдээллийг хүний нөөцийн мэдээллийн систем байршуулан бүтцийн дагуу томилогдон ажиллаж буй албан хаагчдын цалингийн өөрчлөлт, ажилд томилогдсон болон чөлөөлөгдсөн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний өөрчлөлтийг тухай бүрт нь хийж байна.<br>Одоогийн байдлаар 85 албан хаагч тус системд бүртгэгдэж, мэдээллийг шинэчилсэн байна. | 2025.01.<br>02-06.15 | 100 |
| 9 | Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн системд албан хаагчдын өөрчлөлт, хөдөлгөөнийг хийх, эрхийг сэргээх, цаг бүртгэлд хяналт тавина. | Хэрэгжилтийн хувь | 98% | 99% | Төрийн байгууллагын дотоод удирдлагын мэдээллийн системд ( erp.e-mongolia) хүний нөөцийн удирдлага хэсэгт шинээр томилогдсон болон чөлөөлөгдсөн албан хаагчийн бүртгэл, өөрчлөлт, хандах эрх, нэмэлт эрхүүдийг тухай бүрт нь шинэчилж байна. | 2025.01.<br>02-06.15 | 100 |
| 10 | Төрийн албан хаагчийн цалингийн өөрчлөлтийг тухай бүрт нь системд бүртгэх, цаг бүртгэлийг сар бүр гарган цалинг тооцоолуулна. | Цаг бүртгэлийн тоо | 12 | 6 | Ажлын цагийн бүртгэлийг дотоод удирдлагын нэгдсэн системээр хийж, тайлан мэдээг сар бүрээр татан удирдлагуудад танилцуулж байна.<br>6 сарын цагийн тооцоог бодон эрх бүхий албан тушаалтанд танилцуулан баталгаажуулсан. | 2025.01.<br>02-06.15 | 100 |
| 11 | Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, давтан сургах, мэргэшүүлэх, мэргэшлийг | Сургалтын тоо,<br>хамрагдсан | 2<br>50 | 3<br>60 | Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан судалгааг гарган, үр дүнгийн дагуу дараагийн сургалтад хамруулах ажлыг зохион байгууллаа. | 2025.01.<br>02-06.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дээшлүүлэх ажлыг зохион байгуулна. | албан хаагчийн тоо | | | 8 албан хаагч төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад суралцаж байна.<br>Мөн төрийн албан хаагчдыг дээд шатны байгууллагаас зохион байгуулж буй сургалтад оролцуулж, орон нутагт зохион байгуулагдах сургалт, уулзалт, хэлэлцүүлэгт чиглэлийн дагуу оролцуулан мэдлэг чадварыг дээшлүүлэх боломжоор ханган ажиллаж байна. | | |
| 12 | Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, хадгалалт хамгаалалтыг гүйцэтгэнэ. | Хэрэгжилтийн хувь, Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 85%<br>2 удаа | 90%<br>1 удаа | Хувийн хэргээ бүрдүүлсэн төрийн албан хаагчдын хувТөрийн албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтэд Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсэг ажиллах, Төрийн аудитын байгууллагад шалгуулах зорилгоор 2 удаа хяналт хийж, дахин бүрдүүлэх ажлыг зохион байгууллаа.<br>Хувийн хэргийг баталсан кодын дагуу дугаарлан, зориулалтын сейфэд хадгалан аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. | 2025.01. 02-06.15 | 100 |
| 13 | Шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад хамруулах, байгууллагын бүтэц, зохион байгуулалттай танилцуулна. | Сургалтад хамрагдсан албан хаагчийн эзлэх хувь | 80% | 85% | Байгууллагад шинээр томилогдсон НБХ-ийн мэргэжилтэн Э.Төгсжаргал, БОНХОХБТХ-ийн мэргэжилтэн Ч.Дүүрэнбилэг нарт байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, цалингийн шатлал, мэдээлэл зэргийг танилцуулж, төрийн албан хаагчийн богино хугацааны сургалтад хамрагдахыг зөвлөсөн болно. | 2025.01. 02-06.15 | 100 |
| 14 | Төрийн захиргааны албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг үнэлж, үнэлгээний баг ажиллуулах, үр дүнгийн дагуу урамшуулал олгох төслийг боловсруулж, шийдвэрлүүлнэ. | Үнэлгээнд хамрагдсан албан хаагчдын эзлэх хувь | 98% | 99% | Төрийн захиргааны албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг нэгдүгээр улирлаар үнэлж, улирлын мөнгөн урамшуулал олгох журмын дагуу урамшууллыг тооцож олгосон бөгөөд хагас жилийн тайланг үнэлэхээр ажиллаж байна.<br>Хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайланг үнэлэхээр удирдлагын шийдвэрээр Үнэлгээний баг томилогдон ажиллаж байна. | 2025.01. 02-06.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж, улирлын мөнгөн урамшуулал олгуулах асуудлыг шийдвэрлүүлнэ. | Үнэлгээнд хамрагдсан албан хаагчдын эзлэх хувь | 98% | 99% | Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар батлагдсан журмын дагуу улирлын ажлыг дүгнэхээр тайланг хүлээн авч байна.<br>Үнэлгээний үр дүнг эрх бүхий албан тушаалтанд танилцуулж, шийдвэрийг гаргуулах ажиллаж байна. | 2025.01. 02-06.15 | 100 |
| 16 | Байгууллагын албан хаагчдын судалгаа, мэдээллийг холбогдох удирдамж, зааврын дагуу боловсруулж, мэдээллээр хангана. | Гаргасан судалгааны тоо | 2 | 3 | Байгууллагын албан хаагчдын дэлгэрэнгүй судалгааг шинээр томилогдсон албан хаагчдын мэдээллээр баяжуулан шинэчилсэн болно. Мөн шаардлагатай мэдээллийг цаг тухай бүрт нь баяжуулан ажиллаж байна. | 2025.01. 02-06.15 | 100 |
| 17 | Төрийн албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг батлуулж, ээлжийн амралтын мэдэгдэх хуудас, тооцооны хуудсыг хөтөлсөн байна. | Хуваарь батлагдсан эсэх (тийм -1, үгүй -0)<br>Хэрэгжилтийн хувь | 1<br>95% | 1<br>97% | Төрийн албан хаагчдын 2025 оны ажлын жилийн ээлжийн амралтын хуваарийг батлуулахаар албан хаагчдад санал хүргүүлсэн бөгөөд саналын дагуу байгууллагын даргаар батлуулахаар ажиллаж байна. | 2025.01. 02-06.15 | 100 |
| **Зорилт 2. “Иргэдийн санал хүсэлтийг хурдан шуурхай шийдвэрлэж, төрийн үйлчилгээг цахимаар түргэн шуурхай хүргэнэ”** | | | | | | | |
| 1. | Аймгийн Засаг дарга, орлогч дарга, Тамгын газрын даргад хандаж бичгээр, амаар, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвөөр дамжин ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, цахим программ болон өргөдөл, гомдлын бүртгэлийн дэвтэрт бүртгэж, эрх бүхий албан тушаалтанд танилцуулна. | Ирсэн бүх өргөдлийг бүрэн хөтөлсөн хувь | 98% | 100% | Аймгийн Засаг дарга хандаж гаргасан 33 иргэн, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад хандаж гаргасан 10 албан хаагчийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, удирдлагуудад танилцуулан ажиллалаа.<br><br>Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвөөр дамжин ирсэн 56 өргөдөл гомдлыг хүлээн авсан.<br><br>Өргөдөл гомдлыг цохолтын дагуу холбогдох байгууллагад шилжүүлэн ажилласан болно. | 2025.01. 02-06.15 | 100 |
| 2. | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж, шийдвэрлэлтийг программд бүртгэж, хариуг хянан | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь | 85% | 90% | Өргөдөл гомдлыг егр.e-mongolia цахим системд бүртгэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. | 2025.01. 02-06.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баталгаажуулах, хариуг иргэнд хүргэнэ. | | | | 48 иргэний өргөдлийг шийдвэрлэж, шийдвэрлэлтийн хувь 94.5-тай байна. Албан хаагчдын өргөдлийн шийдвэрлэлт 92.8 хувьтай байна. | | |
| 3. | Өөрт цохогдсон өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, хариуг хугацаанд нь хүргүүлнэ. | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь | 85% | 90% | Эрх бүхий албан тушаалтнаас цохогдон ирсэн 6 өргөдөл гомдлыг хүлээн авч, 5 өргөдөл гомдлыг хууль тогтоомж, талуудын тайлбарыг үндэслэн шийдвэрлэж, хариуг иргэнд хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Шийдвэрлэлт 95 хувьтай байна. | 2025.01. 02-06.15 | 100 |
| 4. | Нутгийн захиргааны байгууллагуудад ирсэн өргөдөл, гомдлын мэдээг улирал бүр нэгтгэж, санал дүгнэлтийг Засаг даргын зөвлөлийн хурлаар танилцуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Мэдээг бүрэн нэтгэж, хугацаанд нь хүргүүлсэн тоо | 4 | 4 | Нутгийн захиргааны байгууллагад хандаж ирүүлсэн 1268 өргөдөл гомдлыг бүртгэж, 1217 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн тухай тайлан мэдээг нэгтгэн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилт, хагас жилийн хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.<br><br>Засаг даргын зөвлөлийн хурлын бүрэн эрх байхгүй болсонтой холбогдуулан зөвлөлийн хурлаар танилцуулахыг шаардахаа больсон болно. | 2025.01. 02-06.15 | 100 |
| 5. | Аймгийн Засаг дарга, Нутгийн захиргааны байгууллагад ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн улирлын тайлан, мэдээллийг цахим хуудаст байршуулан, иргэд олон нийтэд танилцуулна. | Цахим хуудаст нийтэлсэн тоо | 2 | 4 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн өргөдөл гомдлын жилийн эцсийн тайлан, мэдээллийг zavkhan.gov.mn цахим хуудаст байршуулан, иргэд олон нийтэд танилцуулсан байна. | 2025.01. 02-06.15 | 100 |
| **Зорилт 3. “Төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг биелүүлнэ.”** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргатай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний холбогдох заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг хангуулан, тайлагнана. | Хэрэгжилтийн хувь | 89% | 95% | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, аймгийн Засаг даргатай 2024 онд хуульд заасан төрийн зарим чиг үүргийг Завхан аймагт төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээг хяналтадаа авч, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Жилийн эцсийн байдлаар 92.0 хувьтай дүгнэгдэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаар гэрээний хэрэгжилт болон хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэн хүргүүллээ. | 2025.01.<br>02-06.15 | 100 |
| 2. | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, төлөвлөгөөний биелэлт, шаардлагатай тоо баримт, мэдээллийг хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллага, хэлтэст хүргүүлнэ. | Биелэлтийн хувь | 90% | 95% | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан нэгжийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ бүрийг хэрэгжүүлэн шаардлагатай баримт, тоон мэдээллийг хугацаанд нь гаргаж ажиллаллаа.<br>Хэрэгжилтийг хагас боловсруулан үнэлгээний багт хүргүүлээд байна. | 2025.01.<br>02-06.15 | 100 |
| 3. | Аймгаас зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, хурал, зөвлөгөөнд бүрэн идэвхтэй оролцож, хэрэгжилтийг хангаж ажиллана. | Оролцооны хувь | 95% | 99% | Аймгийн Засаг даргын бодлого шийдвэрийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцон оролцоог хангаж ажилласан байна.<br>Мөн байгууллагын зүгээс зохион байгуулсан арга хэмжээнд идэвхтэй оролцон хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлсэн байна. | 2025.01.<br>02-06.15 | 100 |
| 4. | Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллана. | Хэрэгжилтийн хувь | 0 | 92% | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар бүрээр гарган, системд мэдээлэн ажиллаж байна.<br>Мөн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хяналт тавьж, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөндөө санал өгч ажилласан. | 2025.01.<br>02-06.15 | 100 |
| **Хэрэгжилтийн хувь** | | | | | | | **99.2** |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | УИХ-ын дарга Д.Амарбаясгалан Завхан аймагт ажиллах бэлтгэл ажлыг хангах, оролцох | Оролцсон эсэх | Тийм | Тийм | УИХ-ын дарга Д.Амарбаясгалан нь 2025 оны 2 дугаар 19-ны өдрөөс ажиллахад бэлтгэл ажлыг хангаж, хурлын арга хэмжээг зохион байгуулсан. | 2025.01.02-06.15 | 100 |
| 2. | Салбарын тэргүүний ажилтан, Шилдэг сум, агентлаг, Аймгийн мэргэд, алдарт уяачдын шагнал гардуулах бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах | Оролцсон эсэх | Тийм | Тийм | 2024 оны үйл ажиллагааны үр дүнгээрээ шалгарсан аймгийн Шилдэг сум, агентлаг, салбарын тэргүүний 10 ажилтан, Шагайн харвааны мэргэд, алдарт уяачдын шагнал гардуулах үйл ажиллагааг Алтан эвент халлд зохион байгуулж, танилцуулга, мэдээллийг бэлтгэн ажиллалаа. | 2025.01.02-06.15 | 100 |
| 3. | Байгууллагын ажил дүгнэх ажлын хэсэгт томилогдон ажиллах | 5-аас доошгүй байгууллагаар ажилласан байх | 5 | 6 | Аймгийн Засаг даргын захирамжаар байгууллагуудын 2024 оны ажил дүгнэх ажлын хэсэгт томилогдож, БСУГ, Статистикийн хэлтэс, ХХҮГ, ХХААГ, Автотээврийн газар, Амь-Ус зэрэг 6 байгууллагад ажиллаж батлагдсан удирдамжийн дагуу ажлын үр дүн, үйл ажиллагаанд үнэлгээ өгч ажилласан. | 2025.01.02-06.15 | 100 |
| 4. | Урд бүсэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх | Сумдад ажилласан тоо | 4 | 4 | Цагаанхайрхан, Цагаанчулуут, Шилүүстэй, Отгон сумдад ажиллаж, төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэлээ. Шалгуур үзүүлэлтийн дагуу зөвлөмж мэдээллээр хангах, төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан байна. | 2025.03.01-2025.06.15 | 100 |
| Хэрэгжилтийн хувь | | | | | | | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Гадаад улсад туршлага судлана. | Туршлага судалсан эсэх | 0 | 0 | Хугацаа хүлээгдэж байна. | 2024.03.01-12.05 | 100 |
| 2. | Албан тушаалын чиг үүргийн хүрээнд ижил түвшний байгууллагуудаас туршлага судалж, сайн туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ. | Туршлага судалсан арга хэмжээний тоо | 0 | 1 | Удирдлагын академиас аймгуудын Хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчдад зориулсан сургалтад 1 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд хамрагдаж, Хөдөлмөрийн эрхлэлтийн харилцаанд анхаарах асуудалтай танилцаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.<br>Монгол Улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт – Сэтгэлгээний өөрчлөлт сэдэвт орон нутгийн сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдаж, сургагч багшаар бэлтгэгдсэн байна. | 2025.01.02-03.17 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ХНӨГХАМ ................................. / Н.Вансэмбэрүү / 2025 . 06 . 15

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )